



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2018 оны 11 сарын 01 өдөр

Дугаар 20

Арвайхээр

Төлөвлөгөө батлах тухай


Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 2.1.2 дахь заалт, Төрийн албаны удирдах ажилтны улсын зөвлөгөөний зөвлөмж, андгайг хэрэгжүүлэх зорилгоор ТОГТООХ нь:

1. “Төрийн албаны удирдах ажилтны улсын зөвлөгөөний зөвлөмж, андгай хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-г хавсралтаар баталсугай.

2. Төрийн албаны удирдах ажилтны улсын зөвлөгөөний зөвлөмж, андгайг хэрэгжүүлэх, төрийн албаны мэргэшсэн, тогтвортой байх, төрийн албан хаагчдын сахилга, хариуцлага, мэргэшлийн чадавхийг нэмэгдүүлэх, ард түмэнд үйлчлэх, төрд чин үнэнчээр зүтгэх зарчмыг баримтлан ажиллахыг төрийн албан хаагчдад үүрэг болгосугай.

3. “Төрийн албаны удирдах ажилтны улсын зөвлөгөөний зөвлөмж, андгай хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-ний биелэлтийг жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор Салбар зөвлөлд тайлагнаж байхыг төсвийн шууд захирагч нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Өвөрхангай аймаг дахь салбар зөвлөлд даалгасугай.

ДАРГА




Ц.ГАНБОЛД

013100039

D:My Doc.togtool TAZ

Төрийн албаны зөвлөлийн Өвөрхангай аймаг дахь Салбар зөвлөлийн 2018 оны 11 дугаар сарын 01-ний өдрийн 10 дугаар тогтоолын хавсралт



ТӨРИЙН АЛБАНЫ УДИРДАХ АЖИЛТНЫ УЛСЫН ЗӨВЛӨГӨӨНИЙ  
ЗӨВЛӨМЖ, АНДГАЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2018.11.01

Арвайхээр

№	Зорилт	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Гүйцэтгэлийн үр дүн	Хэрэгжүүлэх байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
Зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа						
1	Төрийн албаны хүний нөөцийн бодлогын талаар	1.1. Төрийн албаны тухай хуулийн хүрээнд дагалдаж гарах журмуудын төсөлд санал авч, нэгтгэн хүргүүлэх	2018.11.10-ны дотор	Төрийн албан хаагчдын саналыг хүргүүлэх.	Аймгийн Засаг даргын Тамгын газар, Салбар зөвлөл	Төрийн захиргааны байгууллагын удирдлага
		1.2. Төрийн албаны тухай хуулийн хүрээнд батлагдсан дүрэм, журмуудаар байгууллагуудын удирдлага, хүний нөөцийн мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулах, заавар, зааварчилгаа өгөх	2019 оны 1 дүгээр улиралд	Хуулийн үзэл баримтлал, зүйл, заалт, дүрэм, журмуудыг нэг мөр ойлгож хэрэглэнэ.	Аймгийн Засаг даргын Тамгын газар, Салбар зөвлөл	-Төрийн албаны зөвлөл -Удирдлагын академи
		1.3. Төрийн албаны эрх зүйн баримт бичгийн эмхтгэл, гарын авлагыг хэвлүүлэх, албан хаагчдыг зөвлөмж, арга зүйгээр хангах	2019 оны 1 дүгээр улиралд	Хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана.	Аймгийн Засаг даргын Тамгын газар,	Нутгийн захиргааны байгууллагын удирдлага
		1.4. Төрийн албан хаагчийн ажлын байрны болон байгууллагын чиг үүргийн шинжилгээ хийх, албан тушаалын тодорхойлолт боловсруулах чиглэлээр сургалт зохион байгуулж, албан тушаалын тодорхойлолт боловсруулах ажлын хэсэг, мэргэжлийн комиссыг байгууллага бүрт ажиллуулах	2019 оны 1 дүгээр сард	Төрийн албанд нийтлэг болон тусгай шаардлагыг хангасан хүнийг томилон ажиллуулна. Ажлын ачааллыг жигдрүүлнэ.	Аймгийн Засаг даргын Тамгын газар, Нутгийн захиргааны байгууллагын удирдлага	-Төрийн албаны зөвлөл -Удирдлагын академи

		1.5. Төрийн байгууллагуудын стратеги төлөвлөгөөнд хүний нөөцийн бодлогыг тусгаж, хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг хэрэгжүүлэх	2019 оны 1 дүгээр улиралд	Байгууллагын зорилт, чиг үүргийг үр ашигтай, үр нөлөөтэй хэрэгжүүлэх хүний нөөцийг бүрдүүлнэ.	Аймгийн Засаг даргын Тамгын газар, Нутгийн захиргааны байгууллага	Байгууллагын удирдлага
		1.6. Төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалын сул орон тоонд нийтлэг болон тусгай шаардлагыг хангасан иргэнийг сонгон шалгаруулж, томилгооны асуудлыг холбогдох хууль, журмын хүрээнд шийдвэрлэх	2018-2020	Чадахуйн зарчмыг баримтлан, хууль тогтоомж, дүрэм, журмыг мөрдөж ажиллана.	Аймгийн Засаг даргын Тамгын газар, Салбар зөвлөл	Төрийн захиргааны байгууллагын удирдлага
2	Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх, чадавхжуулах талаар	2.1. Төрийн албан хаагчдын сургалтын хэрэгцээг жил бүр тодорхойлж, сургалтын хэрэгцээнд нь тохирсон хөтөлбөр, төлөвлөгөөтэй ажиллах, сургалтын зардлыг байгууллагын төсөвт тусган хэрэгжүүлэх	2018-2020	Сургалт хэрэгцээнд нийцэж үр дүнгээ өгсөн байна.	Нутгийн захиргааны байгууллага	Байгууллагын удирдлага
		2.2. Төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд өөрөө өөрийгөө хөгжүүлэх, мэдлэг, мэргэшлээ дээшлүүлэх болон сургалтын нэрийг тодорхой заах.	2018-2020	Төрийн албан хаагч өөрийгөө хөгжүүлэх, ажлын байрандаа суралцах дадал хэвшлийг төлөвшүүлнэ.	Нутгийн захиргааны байгууллага	Байгууллагын удирдлага
		2.3. Төрийн жинхэнэ албанд томилогдсон (шинээр болон дэвшүүлсэн) албан хаагчийг албан тушаалын чиг үүргийн дагуу богино хугацааны болон мэргэшүүлэх багц сургалтад ажлын гүйцэтгэл, үр дүнг харгалзан хамруулах	2018-2020	Мэргэшүүлэх багц сургалтад ээлж дараатай хамруулсан байна.	Төрийн захиргааны байгууллага	Удирдлагын академи

		2.5. Төрийн албан хаагч бүр хууль, эрх зүй, арга зүйн, статистик мэдээллийг бүрдүүлэх, баяжилт хөдөлгөөн хийж, үйл ажиллагаандаа ашиглах	2018-2020	Хариуцсан чиг үүргийн хүрээнд мэдээллийн санг бүрдүүлж, дүн шинжилгээ хийж ажиллана.	Нутгийн захиргааны байгууллага	Байгууллагын удирдлага
3	Төрийн албан хаагчийн сахилга, хариуцлагын талаар	3.1. Төрийн байгууллагууд хөдөлмөрийн дотоод журам, байгууллагын болон төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд ёс зүй, сахилгын хэм хэмжээг тусган, сахилга, хариуцлагыг дээшлүүлэх талаар бодитой, туршлага болохуйц ажлуудыг зохион байгуулах, сурталчилах	2018-2020	Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилгын зөрчлийн төрлийг зааглаж, хариуцлага хүлээлгэх тодорхой заалтыг журманд тусгана.	Нутгийн захиргааны байгууллага	Байгууллагын удирдлага
		3.2. Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга, хариуцлагыг сайжруулах, манлайллыг дээшлүүлэх чиглэлээр Засгийн газар, Төрийн албаны зөвлөл, аймгийн Засаг даргаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх, сурталчилах, хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах	2018-2020	Хууль, холбогдох шийдвэр, дүрэм, журмыг хэрэгжүүлж, биелэлтийг тайлагнана.	Нутгийн захиргааны байгууллага	Байгууллагын удирдлага
		3.3. Ёс зүйн хорооны үйл ажиллагааг сайжруулах, төрийн албан хаагчийн ёс зүй, сахилгын зөрчилтэй холбоотой шийдвэрийг ил тод зарлах	2018-2020	Ёс зүйн зөрчлийн мэдээллийг ил тод болгоно.	Нутгийн захиргааны байгууллага	Байгууллагын удирдлага
		3.4. Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилгын зөрчилд ногдуулах холбогдох хуулиудын зүйл заалтын талаар мэдээлэл өгөх, ёс зүйн сургалтад хамруулах	2018-2020	Төрийн албан хаагч холбогдох хуулийн ямар зүйл, заалтаар хариуцлага хүлээх талаар судалж мэдсэн байна.	Нутгийн захиргааны байгууллага	Байгууллагын удирдлага

4	Иргэн төвтэй, үр дүнд чиглэсэн төрийн албаны талаар	4.1. Төрийн албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй, үр дүнтэй хүргэх арга хэмжээг тусган, хэрэгжилтэд хяналт тавьж, гүйцэтгэлийг үнэлэх	2018-2020	Бүх шатанд гүйцэтгэлийн болон хяналт-шинжилгээ, үнэлгээг хийнэ.	Нутгийн захиргааны байгууллага	Байгууллагын удирдлага
		4.2. Байгууллагын стратеги төлөвлөгөө, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлагдсан журмын дагуу боловсруулах, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үр дүнтэй уялдуулан урамшуулал, хариуцлагын асуудлыг шийдвэрлэж байх	2018-2020	Төлөвлөгөө нь үр дүнд чиглэсэн, түүний үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлт тодорхой байна.	Нутгийн захиргааны байгууллага	Байгууллагын удирдлага
		4.3. Байгууллагын зорилго, зорилт, чиг үүрэг, төрийн албан хаагчийн ажлын байрны чиг үүрэг, ажлын үр дүн, ёс зүй, сахилга хариуцлагыг хэрэглэгчдээр үнэлүүлэх, түүний мөрөөр холбогдох арга хэмжээ авч ажиллах	2018-2020	Байгууллага, албан хаагчийн ажлын үр дүнг хэрэглэгчийн үнэлгээтэй уялдуулна.	Нутгийн захиргааны байгууллага	Байгууллагын удирдлага
5	5. Төрийн албан хаагчийн үйл ажиллагааны баталгааны талаар	5.1. Төрийн албан хаагчийн цалин хөлс, тусламж, нийгмийн баталгааг хангах талаар байгууллага бүр хөтөлбөр, төлөвлөгөөтэй ажиллаж, хөдөлмөрийн дотоод журамд тодорхой арга хэмжээг тусган хэрэгжүүлэх	2018-2020	Төрийн албан хаагчийн нийгмийн баталгаа сайжирсан байна.	Нутгийн захиргааны байгууллага	Байгууллагын удирдлага
		5.2. Төрийн албан хаагчийн албан тушаалын цалин хөлс, нэмэгдлийг мэргэжлийн ур чадвар, ажлын ачаалал, ажлын дадлага туршлага зэргийг харгалзан бодитой шударга тогтоох	2018-2020	Тохирсон цалин хөлсийг шударга байдлаар тогтооно.	Нутгийн захиргааны байгууллага	Байгууллагын удирдлага

		5.3. Төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг бодитой үнэлж дүгнэн, ажлын үр дүнтэй уялдуулж албан хаагчид зэрэг дэв олгох, ахиулах, бууруулах, зэрэг дэвийг хүчингүй болгох, үр дүнгийн урамшуулал, нэмэгдэл олгох, шатлан дэвших зэрэг асуудлыг шийдвэрлэх	2018-2020	Үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинтэй уялдуулж үүрэг, хариуцлагыг дээшлүүлнэ.	Нутгийн захиргааны байгууллага	Байгууллагын удирдлага
<b>Андгайн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа</b>						
1	Төрийн албан хаагчийн ёс зүйг чанд сахих, авлига, хээл хахуулд өртөхгүй байх	1.1. Төрийн албан хаагчдад андгайг танилцуулах, үйл ажиллагаандаа мөрдлөг болгох байгууллагын вэб сайт, самбарт байршуулах, сурталчилах	2018 оны 10 сард	Андгайг хэрэгжүүлж ажиллана.	Нутгийн захиргааны байгууллага	Байгууллагын удирдлага
		1.2. Авлигын эсрэг хууль тогтоомж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, байгууллага бүр авлигаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөөтэй ажиллаж, бодлогын баримт бичгийг хөндлөнгийн байгууллагаар үнэлүүлэх	2018-2020	Хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтэд үнэлгээ хийж ажиллана.	Хууль, эрх зүйн хэлтэс	Төрийн бус байгууллага
		1.3. Төрийн албаны тухай хууль тогтоомж, Авлигын эсрэг хуулиар төрийн албан хаагчдаас эрх зүйн мэдлэгийн шалгалт авах, ажлын байранд сургах	2018-2020	Төрийн албан хаагчдын эрх зүйн мэдлэг дээшилнэ.	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Хууль, эрх зүйн хэлтэс	Салбар зөвлөл
		1.4. Төрийн үйлчилгээг хүргэхдээ хэнийг ч үл ялгаварлан, тал тохой татахгүй, тэгш хүртээмжтэй хандах	2018-2020	Иргэдийн төрд итгэх итгэл үнэмшил, сэтгэл ханамжид эерэг өөрчлөлт гарна.	Нутгийн захиргааны байгууллага	Төрийн албан хаагчид